



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 19 өдөр

Дутаар А/29

Мандагтовь

**“Хүчирхийлэлгүй байя” аян
зохион байгуулах тухай**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6, Монгол Улсын Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэл түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлөвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүчирхийлэлгүй байя” аяныг 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 24-ний өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. “Хүчирхийлэлгүй байя” нөлөөллийн аян зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 343.000 (Гурван зуун дөчин гурван мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

491190200